

“ГАХАЙН АЖ АХУЙ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. “Гахайн аж ахуй” аймгийн дэд хөтөлбөрийн өнөөгийн байдал

Тус аймагт 1971 оноос үржүүлж эхлэхдээ 1171 толгой гахай тоологдон 1989 онд 17968 толгой хүрч байсан бол 2016 онд 0,4 хувиар буурч 1083 толгой гахай тоологдоод байна.

Гахайн туслах аж ахуйгаас үйлдвэрийн аргаар боловсруулж бэлтгэсэн махыг хүн амын дотоодын хэрэгцээг хангах юм.

Энэ нь гахай аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлж орчин үеийн стандарт, шаардлагын дагуу боловсруулж аймгийнхаа иргэдэд эрүүл, хүнс нийлүүлэх зайлшгүй шаардлага тулгарсныг харуулж байна.

Орон нутагтаа дасан зохицсон гахай аж ахуйг хөгжүүлэх, тоо, толгой нэмэгдүүлэх нь зүйтэй юмаа.

Монгол улсын хэмжээнд гахайн махны жилийн хэрэгцээ 5000 тн дунджаар байдаг. Нийслэл хот дангаараа үүний 80 гаруй хувь буюу 3800-4000 тн дунджаар хэрэглэдэг судалгаа хийгдээд байна.

Манай аймаг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2004 оны 26 дугаар тогтоолоор аймгийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд тус аймагт 2008-2014 онууд 3 аж ахуйн нэгжид “Махны чиглэлийн арвин ашиг өндөртэй “Ландрас” үүлдрийн 6,650,0 төгрөгийн үнэ бүхий 9 мэгж, 1 бодон олгож 4 иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэн 2000 толгойд хүрсэн байна. Гэвч хөтөлбөр хэрэгжих хугацаанд л гахайн тоо, толгой өссөн боловч одоо иргэдийн үржүүлж байгаа гахайн нь үүлдэр нь тодорхойгүй, цөөн тооны өрхийн хэрэглээний хэлбэрт шилжээд байна.

Гахай аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтворжуулахад холимог тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар олон наст тэжээлийн ургамал тариалах, зах зээлийн судалгаа үнэн бодитой хийгдсэн байна.

Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг эрчимжсэн аж ахуй, эрхлэх бүс нутгаа тодорхойлон сонгон шалгаруулалтаар иргэн, аж ахуйн нэгжид бэлчээрийн газар ашиглуулах шаардлагатай.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага. Үндэслэл

Монгол улсын гахай үржүүлэгчид ихэвчлэн өрх гэрийн хэрэгцээг хангах бага хүчин чадал бүхий жижиг аж ахуйнууд зонхилж байна. Нийт гахайн 86.6% нь хувийн аж ахуй буюу өрхийн үйлдвэрлэл ажээ. Өнгөрсөн он жилүүдэд Төв бүсэд хэрэгжиж байсан гахайн чиглэлийн төслийн судалгаанаас харахад гахайн махаа 100% дотооддоо хэрэглэдэг. Харин гахайн мах өөхний хомсдоллоос улбаалан гадаадаас импортолдог болсон байна.

Сүүлийн жилүүдэд хиам боловсруулах үйлдвэрүүд өөрийн үндсэн түүхий эд гахайн өөхийг хөрш орнуудаас импортолж байгаа бөгөөд өмнөд хөршид шүлхий өвчин гарсан үеэр Европын Холбооны орнуудаас их хэмжээгээр оруулж ирж байгаа ч дотоодын хэрэгцээгээ хангахын тулд цаашлаад гадаадын зах зээлд импортлохын тулд гахайн эрчимжүүлсэн аж ахуйг байгуулах шаардлага байна.

Сүүлийн 3 жилд гахайн тоо, толгой жилээс жилд буурсан үзүүлэлттэй гарч байна.

2016 оны мал, тэжээвэр амьтан 48 өрх, 1 аж ахуйн нэгжид 1083 толгой гахай тооллогоор эрчимжсэн аж ахуй чиглэлээр 1 аж ахуйн нэгж, гахай 12 иргэнд нийт 669 толгой гахай үржүүлж жилдээ 12 тн гахайны мах үйлдвэрлэсэн байна.

Хүн амын хүнсний хэрэгцээний тодорхой хэсэг болох гахайн махны нөөц бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа бөгөөд цогц хэлбэрээр загвар аж ахуй шинээр бий болгоход гахайг 3 хэвшлээр үржүүлэх хэрэгтэй.

1. Үржлийн чиглэлтэй аж ахуй
2. Үржлийн болон хэрэгцээний аж ахуй
3. Хэрэгцээний аж ахуй

ҮРЖЛИЙН АЖ АХУЙ: Цэвэр үржүүлгийн арга, нэг үүлдрийн удам доторх болон тэдгээрийн хоорондох үржүүлгийн аргыг голлон ашиглахаас гадна сүргийн нөхөн үйлдвэрлэлээр нь өсгөх, дотор нь селекц явуулах боломж бүрдүүлэх, төрлийн үржүүлэг явуулахгүй байх зорилгоор 100-аас доошгүй үндсэн мэгжтэй байна.

Аж ахуйдаа үржлийн бүртгэл мэдээллийг бүрэн хөтөлсний үндсэн дээр гарал үүсэл тодорхой, бие цогцос, өсөлт хөгжилт сайтай гахайг сонгож, үржлийн зориулалтаар бусад аж ахуйд нийлүүлнэ.

ҮРЖЛИЙН БОЛОН ХЭРЭГЦЭЭНИЙ ХОСОЛМОЛ АЖ АХУЙ: 1 болон 2 түүнээс дээш тооны үүлдрийн гахай үржүүлж болохоос гадна цэвэр үржүүлгийн ба эрлийзжүүлгийн аргуудыг ашиглаж өөрөө, өөрийгөө үржлийн сүргээр хангахаас гадна эрлийз торой бойжуулж махны зориулалтаар борлуулна.

ХЭРЭГЦЭЭНИЙ АЖ АХУЙ: Жижиг аж ахуй болон дан махны үйлдвэрлэх боломжтой томоохон хэрэгцээний аж ахуйнууд багтана. Хэрэгцээний нөхөн үйлдвэрлэх чадвар, ашиг шим, амьдрах чадварыг өндөр байлгахын тулд үржлийн аж ахуйнуудаас бодон мэгжээ худалдан авч эх сүргээ бүрдүүлнэ. Түүнчлэн олон төрлийн үүлдүүдийг үржүүлж, хэрэгцээний эрлийзжүүлэг явуулж, мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилгууд

3.1. Аймгийн хүн амийн хэрэгцээг хангах, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвар бүхий эдийн засгийн үр ашиг нэмэгдүүлсэн, эрүүл, аюулгүй хүнс үйлвэрлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Төвийн бүс нутагт тохирсон гахайн загвар аж ахуйг бий болгож, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, хэрэглэгчдийн мэдлэгийг сайжруулах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах.

3.2.2. Гахайн аж ахуйн чадавхыг дээшлүүлэн мах боловсруулах үйлдвэрлэл түүний бүтээгдэхүүний чанар, савалгааны технологийг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат

4.1. Энэ хөтөлбөрийг 2017-2025 оныг дуусталх хугацаанд жил бүрийн ажлын төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Эхний шат - 2017-2021 Гахай аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх, зах зээлд өсөлт гаргах эрх зүйн орчин бүрдэнэ.

4.2.2. Хоёр дахь шат - 2022-2025 Орон нутагтаа аж ахуй эрхлэх тогтолцоо бий болох, мах үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнээр зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанартай, аюулгүй бүтээгдэхүүн борлуулах, экспортын нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрыг чиглэл өгсний дагуу мэргэжил арга зүйгээр хангах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг хүлээнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулан, биелэлтийг гаргаж, үр дүнг тооцно.

5.3. Хөтөлбөрт шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцон, батлуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

6.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж олгох хөрөнгө

6.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

6.3. Сум хөгжүүлэх сан

6.4. Урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл

6.4. Олон улсын болон гадаадын байгууллагын хөрөнгө оруулалт, зээл тусламж

6.5. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж

6.6. Тухайн иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

7.1. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гахайн махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх хүчин зүйлүүд болох төлөрхөг чанар өндөртэй түргэн өсөлттэй, тэжээл нөхөх чадвар сайтай, тэжээл боловсруулах үйлдвэрлэлд шинжлэх ухаан технологийн ололтыг нэвтрүүлэн бүрэн механикжсан загвар аж ахуйн суурийг бий болгож зохион байгуулна.

7.1.1. Хөтөлбөрийн 3.2.1-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

7.1.1.1. Аймаг, сумдын бэлчээрийн төлөв байдлыг тогтоож, даацыг зөв тодорхойлсноор гахайн аж ахуйн үйлдвэрлэлийн оновчтой хэлбэр, тоо хэмжээний зохистой бүтцийг боловсруулан, сурталчилна.

7.1.1.2. Гахайн аж ахуйг ихэвчлэн үр тарианы бүс нутагт болох зах зээлд ойрхон байрлах ба зам харилцаа хөгжисөн, цахилгаан, усны нөөцийг хэрэгцээг түшиглэн байгуулна.

7.1.1.3. Гахайн аж ахуй эрхлэгчид олон найрлагад тэжээлийн ургамал тариалах газрын асуудлыг шийдвэрлэн өгөх боломжийг олгоно.

7.1.1.4. Гахайн аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн ашиг орлогын нэмэгдүүлэхэд шинэ арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр болон Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

7.1.1.5. Аймгийн хэмжээнд шинээр 2 загвар аж ахуйг байгуулахад Засгийн газрын болон орон нутгийн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, тусламж, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг авах бүхий л боломжийг судлан хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

7.1.1.6. Гахайн аж ахуй эрхлэгч нарт тэжээлийн ургамлыг тариалах нөхцөл бололцоог хөхүүлэн дэмжисэн байна.

7.1.1.7. Өндөр ашиг шимт гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн хооронд үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг бодлогын хэмжээнд зохион байгуулна.

7.1.1.8. Иргэд, аж ахуй нэгжүүдэд сурталчлан, аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн нийтийн сургалт, танилцах аялал зохион байгуулах, гарын авлага, зөвлөмж хэвлүүлэн сурталчилна.

7.1.2. Хөтөлбөрийн 3.2.2-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.2.1. 8-50 хүртэл үндсэн мэгжийн гахайн ферм нь өвөл, зуны дулаан, хуурай, агааржуулалт сайтай технологийн шаардлага байранд үйл ажиллагаа явуулна.

7.1.2.2. Гахай эрхлэгч нарыг хоорондоо хөрөнгө хүчээ нэгтгэн хорших, хамтын хөдөлмөр эрхлэх замаар мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.

7.1.2.3. Гахайн эрчимжүүлсэн аж ахуйн мал эмнэлэг, ариун цэврийн асуудлыг сайн шийдвэрлэснээр халдварт өвчин гарах магадлалыг бууруулна.

7.1.2.4. Зохио хууль тогтоомжийн дагуу арвин ашиг шимт гахайг даатгалд хамруулах арга хэмжээг авна.

7.1.2.5. Гахайн мах боловсруулах үйлдвэрийг шинээр барьж байгуулснаар хүн амын хүнсний хангамжийн тодорхой хувийг бүрдүүлнэ.

7.1.2.6. Мах, өөхний чиглэлийн төлөрхөг чанар өндөртэй гахайг үржүүлж, нядлагын гарцыг нэмэгдүүлж, тоо, толгой өсгөснөөр биологийн нөөц бололцоог ашиглана.

7.1.2.7. Шинэ техник, технологийг судлан, олон найрлагат тэжээлийн үйлдвэр байгуулан ажиллуулах санаачилгыг дэмжинэ.

7.1.2.8. Цөм сүргийн гахайн аж ахуйн бүртгэл хөтлөлт, хээлтүүлэгч бойжуулах, худалдан борлуулахдаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилласан байна.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

8.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна.

8.1.1. Аймгийн хэмжээнд гахайн 2 загвар аж ахуй байгуулан хөтөлбөрт тусгагдсан зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

8.1.2. Хүчит болон биологийн гаралтай тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэн гахай аж ахуйн тэжээллэгийн технологийг мөрдөх нөхцлийг бүрдүүлнэ.

8.1.3. Арвай, хөх тариа, вандуйн тариалалтыг нэмэгдүүлснээр гахайн махны чанар сайжирсан байна.

8.1.4. Гахай аж ахуйгаас авах үр, өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө, санхүүгийн болон технологийн асуудлыг шийдвэрлэснээр гахайн махны үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн хүнсний багагүй нөөцийг бий болгоно.

8.1.5. Олон найрлагат тэжээлийн 1 үйлдвэр байгуулж, материаллаг бааз суурийг нэмэгдүүлэн технологийн чанарын өөрчлөлт гарсан байна.

8.1.6. Аймгийн хүн амын хэрэгцээг чанартай бүтээгдэхүүнээр, жигд хангах асуудлыг сайжруулан махны хэрэгцээг хангасан байна.

8.1.7. Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс Хүнс, хөдөө аж ахуйн газар